

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам"-ыг хэрэгжүүлэхэд энэхүү зөвлөмжийг мөрдөнө.

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн боловч дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагч гэдгийг дараах байдлаар ойлгоно.

1.1.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон тухайн үед мөрдөж байсан шимтгэлийн хувь, хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол, хугацаанд нь төлсөн;

1.1.2. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдахын өмнөх 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй; /Жишээ нь: 2014 онд эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдах даатгуулагч 2011 оны 01 дүгээр 01-ний өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлээгүй, эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний зардал гаргуулаагүй/.

1.2. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэгт зааснаар даатгуулагч шимтгэлээ нөхөн төлсөн тохиолдлыг тасралтгүй төлсөн хугацаанд тооцохгүй. /Жишээ нь: Даатгуулагч Д нь 2012 оны эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөхгүй байж байгаад 2013 онд нөхөн шимтгэл хийсэн тохиолдол/.

1.3. Ажил хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлж байсан даатгуулагчийн жилд шимтгэл төлөх хугацаа тасарсан нь тухайн даатгуулагчийн ээлжийн амралттай байх хугацаа болох нь нотлогдвол тухайн даатгуулагчийн амралттай байх хугацааг шимтгэл төлснөөр тооцно.

### **Хоёр. Нийгмийн даатгалын байгууллагууд:**

2.1. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 17 дугаар тогтоолоор баталсан, "Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам"-ыг хэлтсийн нийт ажилтанд танилцуулж, энэ талаар сурталчлах ажлыг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

2.2. Урамшуулалд хамрагдах болзол хангасан даатгуулагчийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын <http://www.ndaatgal.mn/> вэб сайтны баруун хэсэгт байрлах "Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт

хамрагдах эсэхээ шалгах” хэсгээр “emd3” програмын нэвтрэх эрхээр орж шалгана.

Хавсралт 2. /“emdprom3” вэб програм ашиглах заавар/

- 2.3. Даатгуулагчийн регистрийн дугаараар шалгахад тухайн даатгуулагчийн мэдээлэл олдохгүй тохиолдолд даатгуулагч 3 жилийн хугацаанд ЭМД-ын шимтгэлийг хугацаанд нь тэмдэглээгүй эсвэл даатгуулагчийн регистрийн дугаар алдаатай байх магадлалтай тохиолдолд тухайн даатгуулагчийн мэдээллийг “**ndlav**” програмаас шалгах, ЭМД-ын шимтгэлээ тасралтгүй, хугацаанд төлсөн нь тодорхой бус эсвэл регистрийн дугаар нь алдаатай гэж үзвэл даатгуулагчийн мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газарт даатгуулагчийн мэдээллийг хүргүүлж шалгуулна.
- 2.4. Сонгогдсон эрүүл мэндийн байгууллагатай Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн/ Багануур, Налайх/ нийгмийн даатгалын хэлтэс даатгуулагчид урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээг байгуулна.
- 2.5. Тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь урамшууллын эрх үүссэн даатгуулагчид оношлогоо, шинжилгээний 3 багцаас сонголт хийлгэж, тухайн сонгосон оношлогоо, шинжилгээний хуудсыг хэвлэн, тус хуудасны зүүн дээд талд болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээний тухайн жилийн хуудасны дээд талд “*Даатгуулагчийн урамшуулал*” гэсэн дардсыг дарж баталгаажуулна.
- 2.6. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгийн эрх үүссэн даатгуулагчийг мэдээллээр ханган эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ болон оношлогоо, шинжилгээний хуудсанд “*Даатгуулагчийн урамшуулал*” гэсэн баталгаажилтыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст Эрүүл мэндийн даатгалын алба, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст Үйлчилгээний алба тус тус эрхлэн гүйцэтгэнэ.
- 2.7. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн даатгуулагчийн урамшуулах үзлэгийн зардлын нэхэмжлэлийг цаасаар болон файлаар хүлээн авч мэдээллийн баазад шалган нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэлээр шилжүүлнэ.
- 2.8. Даатгуулагч оношлогоо, шинжилгээний хуудсаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд өргөдөл бичүүлэн дахин олгож болох ба хавсралт 1-д заасан жагсаалтын тайлбар хэсэгт дахин олгосон гэсэн тэмдэглэгээг хийнэ.
- 2.9. Даатгуулагч хүндэтгэх шалтгааны улмаас урамшууллын үзлэгтээ 30 хоногийн дотор хамрагдаагүй тохиолдолд өргөдөл бичүүлэн оношлогоо, шинжилгээний хуудсанд болон хавсралт 1-д заасан жагсаалтын тайлбар хэсэгт тэмдэглэгээг хийнэ.

## Гурав. Эрүүл мэндийн байгууллагууд:

- 3.1. Сонгогдсон эрүүл мэндийн байгууллага нь Нийгмийн даатгалын байгууллагатай “Даатгуулагчид урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ”-г байгуулна.
- 3.2. Тухайн эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн урамшуулах эрх авсан даатгуулагчийн мэдээлэл болон 30 хоногийн хугацаандаа хандаж байгаа эсэхийг ndaatgal.mn цахим хуудсанд суурилсан “emdprom3” вэб програмаас болон цахим үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, оношлогоо, шинжилгээний хуудас зэргийг үндэслэн шалгана.
- 3.3. Эрүүл мэндийн байгууллага нь “emdprom3” вэб програмын эмнэлэгт нэвтрэх хэсгээр орон “eclaim” програм хангамжийн эрхээр нэвтрэх бөгөөд “eclaim” програмд нэвтрэх эрхгүй бол Эрүүл мэндийн даатгалын газраас нэвтрэх эрхийг авна. Хавсралт 3 /“emdprom3” вэб програм ашиглах заавар/
- 3.4. Даатгуулагч урамшууллын эрхээ баталгаажуулснаас хойш 30 хоногийн хугацаа хэтэрсэн тохиолдолд тухайн эмнэлэг үйлчлэхгүй.
- 3.5. Эрүүл мэндийн байгууллага нь даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд “emdprom3” програмын **“үйлчлүүлсэн тул тэмдэглэх”** товчийг дарж тухайн даатгуулагчдад үйлчилгээ үзүүлснээ баталгаажуулна.
- 3.6. “Даатгуулагчийн урамшуулал” авсан даатгуулагчийн үзлэг оношлогоо, шинжилгээг гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллага нь мэргэжлийн түвшинд, нэмэлт төлбөргүйгээр, чанартай, түргэн шуурхай, хийж гүйцэтгэнэ.
- 3.7. Эрүүл мэндийн байгууллага нь зөвхөн даатгуулагчийн сонгосон багцын оношлогоо, шинжилгээг бүрэн хийнэ. Сонгоогүй багцын оношлогоо, шинжилгээнүүдийг хийхийг хориглоно.
- 3.8. Даатгуулагчийн оношлогоо, шинжилгээний хариуг үндэслэн амбулаторийн картанд дүгнэлт бичиж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх эмчилгээний чиглэл, зөвлөмж өгнө.
- 3.9. Эрүүл мэндийн байгууллага нь урамшууллын үзлэгт хамрагдсан даатгуулагчийн оношлогоо, шинжилгээ, эмчийн үзлэгийн дүгнэлтийг үндэслэн, тухайн даатгуулагч “эрүүл” тохиолдолд ӨОУА-ын “U” оношийн кодоор, өөрчлөлттэй тохиолдолд тухайн өвчний оношийн кодоор бүртгэж, Нийгмийн даатгалын байгууллагад мэдээлнэ.
- 3.10. Эрүүл мэндийн байгууллага урамшууллын үзлэгт хамрагдсан даатгуулагчийн мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн сайдын 2010 оны

17 дугаар тушаалаар баталсан маягт /АМ-1Б/-ын дагуу цаасаар болон файлаар нийгмийн даатгалын байгууллагад дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

- 3.11. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчилсан мэдээллийн самбар ажиллуулж, даатгуулагч /иргэд/-д эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах арга хэмжээг зохион байгуулна.
- 3.12. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамруулахдаа холбогдох журам, зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөр олгохгүй ба энэ тохиолдолд гарсан зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

#### **Дөрөв. Даатгуулагчид:**

- 4.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн боловч дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй буюу эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний зардлын төлбөр гаргуулаагүй даатгуулагч урамшууллын үзлэгт хамрагдана.
- 4.2. 0-16 /ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 хүртэлх/ насны хүүхэд урамшууллын үзлэгт хамаарагдахгүй.
- 4.3. Урамшууллын эрх бүхий даатгуулагч урамшууллын үзлэг үзүүлэхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудаас зөвхөн нэг эрүүл мэндийн байгууллагыг харьяалал харгалзахгүйгээр сонгох эрхтэй.
- 4.4. Даатгуулагч Нийгмийн даатгалын ерөнхий газрын <http://www.ndaatgal.mn/> вэб сайтны баруун хэсэгт байрлах “Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт хамрагдах эсэхээ шалгах” хэсгээр эсвэл <http://www.ndaatgal.mn/emdprom3/> холбоосоор орон өөрийн регистрийн дугаараараа урамшууллын үзлэгийн талаарх дараах дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.
  - урамшууллын эрх үүссэн эсэхээ шалгах
  - урамшууллын журам, багцтай танилцах,
  - урамшууллын үзлэг хийх эрүүл мэндийн байгууллагын нэрсийн жагсаалт
- 4.5. Урамшууллын эрх бүхий даатгуулагч оношлогоо, шинжилгээний 3 төрлийн багцаас зөвхөн 1 багцыг сонгох эрхтэй. Багц бүрээс шинжилгээний тодорхой хэсгийг сонгох боломжгүй.
- 4.6. Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын гэрчилгээндээ “*Даатгуулагчийн урамшуулал*” -ийн баталгаажуулалт хийлгэснээс хойш 30 хоногийн дотор урамшууллын үзлэгтээ хамрагдана.

- 4.7. Даатгуулагч хүндэтгэх шалтгааны улмаас урамшууллын үзлэгтээ 30 хоногийн дотор хамрагдаагүй тохиолдолд харьяа нийгмийн даатгалын хэлтэст өргөдөл гарган оношлогоо, шинжилгээний хуудасдаа тэмдэглэл хийлгэн сонгосон эрүүл мэндийн байгууллагадаа үзлэгтээ хамрагдана.
- 4.8. Даатгуулагч өөрийн сонгосон эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ иргэний цахим үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, оношлогоо, шинжилгээний хуудас, амбулаторийн үзлэгийн картаа авч очно.
- 4.9. Оношлогоо, шинжилгээний хуудсаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд харьяа нийгмийн даатгалын хэлтэст өргөдөл гарган дахин авч болно.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

**Урамшууллын эрх бүхий даатгуулагчийн жагсаалт**

№	Овог нэр	Регистрийн дугаар	Бүртгэсэн он, сар, өдөр	Сонгосон		Тайлбар
				Багц	Эрүүл мэндийн байгууллага	


## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ЭСЭХИЙГ ШАЛГАХ ПРОГРАМ (emd3) АШИГЛАХ ЗААВАР

### (Нийгмийн даатгалын хэлтэс)

**Программын зорилго:** Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшууллын үзлэгт хамрагдах болзол хангасан эсэхийг регистрын дугаараар нь шалгаж, шаардлага хангасан даатгуулагчийн урамшууллын эрхийг баталгаажуулж, сонгосон багцыг тэмдэглэх

### Програм ашиглах заавар

1. [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) цахим хуудсаны баруун талд байрлах “Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт хамрагдах эсэхийг шалгах” гэсэн холбоосоор орно.



2. Нийгмийн даатгалын хэлтсийн нэвтрэх хэсгээр орж аймаг, дүүргээ сонгон “emd3” програмд ордог хэрэглэгчийн нэр, нууц үгээр нэвтрэн орно.

Энд дарна уу!

нд хэлтэс нэвтрэх ЭМНЭЛЭГ НЭВТРЭХ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧ ТА УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТЭЭ ХАМРАГДААРАЙ**

Даатгуулагч Та дараах нөхцөлийг хангасан тохиолдолд урамшууллын оношлогоо, шинжилгээний багцаас сонгон нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмнэлэгүүдэд эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамрагдах эрхтэй. Үүнд :

- ✓ Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол хугацаанд нь төлсөн бол
- ✓ Дараалсан 3 жилийн хугацаанд буюу 2011/01/01 -ээс 2014/01/01 -ний хоорондох хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөр гаргуулаагүй бол.

Даатгуулагч Та урамшууллын оношлогоо шинжилгээний багц болон эмнэлэгээ өөрөө сонгох боломжтой.

Багц -1 харах      Багц -2 харах      Багц -3 харах      Эмнэлэгүүдийн нэрс харах

Даатгуулагч Та урамшууллын үзлэгт хамрагдах эрх үүссэн эсэхээ регистрийн дугаараа оруулан шалгана уу.

Регистрийн дугаара оруулна уу:

Аймаг/Дүүрэг :

Хэрэглэгч :

Нууц үг :

✓ Аймаг, дүүргээ сонгож  
✓ “EMD3” программын  
эрхээр нэвтрэнэ үү!

3. Даатгуулагчийн регистрийн дугаарыг оруулж урамшууллын болзол хангасан эсэхийг шалгана.

Баянгол - ПРОГРАМААС ГАРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛАЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ БҮРТГЭХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

Даатгуулагчийн регистрийн дугаарыг оруулж шалгах товчийг дарна уу!

4. Даатгуулагч урамшууллын үзлэгт эрхтэй бол:

- Тухайн даатгуулагчийн сонгосон урамшууллын оношлогоо, шинжилгээний багцыг сонгон хадгална.
- Даатгуулагчийн сонгосон багцыг хэвлэн тухайн багцын хуудас болон “Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ”-нд “Урамшууллын эрх”-ийн баталгаажуулж дардас дарна.

Баянгол - ПРОГРАМААС ГАРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛАЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ БҮРТГЭХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

регистрийн дугаартай ЦЭДЭНИШ овогтой МАШБАТЭМДБ -н урамшууллын баталгаажуулалтыг 2014-08-08 -ны өдөр бүртгэсэн бөгөөд эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аваагүй байна. Даатгуулагч нь Багц-1 -г сонгосон байна. [ХЭВЛЭХ](#)

Нөхдүгээр багц

2. “Хэвлэх” товчийг дарж хэвлэн даатгуулагчид баталгаажуулалтын дардас дарж сонгосон хуудсыг өгнө үү.

1. Даатгуулагчийн сонгосон багцыг сонгон “Хадгалах” товчийг дарна уу!

5. Хэрэв даатгуулагч урамшууллын оношлогоо, шинжилгээнд хамрагдах боломжгүй бол:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛАЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ БҮРТГЭХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

регистрийн дугаартай даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын дараах тусламж, үйлчилгээ авсан тул урамшууллын үзлэгт хамрагдах боломжгүй байна. Үүнд :

Тусламж үйлчилгээ авсан огноо	Тусламж, үйлчилгээний төрөл	Эрүүл мэндийн байгууллагын нэр
-	Эмийн үнийн хөнгөлөлт	ТЕХЕМ ФАРМ эмийн сан - Улаанбаатар
2013-08-05	Нөхөн сэргээх	ШАРГАЛЗУУТ Р/ СУВИЛАЛ - Баянхонгор

Тухайн даатгуулагчийн ямар тусламж, үйлчилгээ, хаана, хэзээ авсан мэдээлэл гарч ирнэ.

6. Хэрэв даатгуулагч урамшууллын оношлогоо, шинжилгээнд хамрагдсан бол:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛАЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ БҮРТГЭХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

регистрийн дугаартай САРАНЧИМЭГ овогтой СУВДАА - н урамшууллын баталгаажуулалтыг 2014-08-07 -ны өдөр бүртгэсэн бөгөөд 2014-08-07 -ний өдөр Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл эмнэлгээр үйлчүүлсэн байна.

Тухайн даатгуулагчийн хэзээ, хаана урамшууллын үзлэгт хамрагдсан мэдээлэл гарч ирнэ.



7. Хэрэв даатгуулагчийн регистрийн дугаараар шалгахад тухайн даатгуулагчийн мэдээлэл олдохгүй бол:

- а. Даатгуулагч 3 жилийн хугацаанд ЭМД-ын шимтгэлээ төлөөгүй,
- б. Эсвэл даатгуулагчийн регистрийн дугаар алдаатай байна гэсэн үг.

Тухайн даатгуулагчийн мэдээллийг “**ndlav**” програмаас шалгаж ЭМД-ын шимтгэлээ тасралтгүй, хугацаанд төлсөн эсвэл регистрийн дугаар нь алдаатай гэж үзвэл даатгуулагчийн мэдээллийг НДЕГ-ын дэргэдэх ЭМДГ-т хүргүүлж шалгуулна уу.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛАЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ БҮРТГЭХ СИСТЕМ**

Регистрийн дугаар оруулна уу :

XXXXXXXXXX

ШАЛГАХ

Мэдээлэл олдсонгүй.


## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ЭСЭХИЙГ ШАЛГАХ ПРОГРАМ (emdprom3) АШИГЛАХ ЗААВАР

### (Эрүүл мэндийн байгууллага)

**Програмын зорилго:** Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт хамрагдах болзол хангаж, ЭМД-ын гэрчилгээ болон сонгосон багцын хуудас дээр баталгаажуулалт хийлгэсэн даатуулагчийг шалгаж, оношлогоо, шинжилгээнд хамруулсан тэмдэглэл хийх

### Програм ашиглах заавар

8. [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) цахим хуудасны баруун талд байрлах “Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт хамрагдах эсэхийг шалгах” холбоосоор орно.



9. **Эмнэлгийн нэвтрэх** хэсгээр орж аймаг, дүүрэг болон өөрийн эмнэлгээ сонгон **“eclaim”** програмын эрхээр нэвтрэн орно. Хэрэв эмнэлэг “eclaim” програмд бүртгэлгүй бол Нийгмийн даатгалын байгууллагаас нэврэх эрх олгоно.

Энд дарна уу!

**НД ХЭЛТЭС НЭВТРЭХ** **ЭМНЭЛЭГ НЭВТРЭХ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧ ТА УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТЭЭ ХАМРАГДААРАЙ**

Даатгуулагч Та дараах нөхцөлийг хангасан тохиолдолд урамшууллын оношлогоо, шинжилгээний багцаас сонгон нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмнэлэгүүдэд эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамрагдах эрхтэй. Үүнд :

- ✓ Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол хугацаанд нь төлсөн бол
- ✓ Дараалсан 3 жилийн хугацаанд буюу 2011/01/01 -ээс 2014/01/01 -ний хоорондох хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөр гаргуулаагүй бол.

Даатгуулагч Та урамшууллын оношлогоо шинжилгээний багц болон эмнэлэгээ өөрөө сонгох боломжтой.

Багц -1 харах      Багц -2 харах      Багц -3 харах      Эмнэлэгүүдийн нэрс харах

Даатгуулагч Та урамшууллын үзлэгт хамрагдах эрх үүссэн эсэхээ регистрийн дугаараа оруулан шалгана уу.

Регистрийн дугаара оруулна уу:

**Аймаг/Дүүрэг :**

**Эмнэлэгийн нэр :**

**Хэрэглэгч :**

**Нууц үг :**

- ✓ Аймаг, дүүрэгээ сонгоно
- ✓ Эмнэлгээ сонгоно
- ✓ “eclaim” програмын эрхээр нэвтрэч орно үү!

10. Нийгмийн даатгалын байгууллагаас баталгаажуулсан даатгуулагчийн “Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ” болон сонгосон “Оношлогоо, шинжилгээний багцын хуудас”-ыг үндэслэн даатгуулагчийн регистрийн дугаарыг оруулж урамшууллын үзлэгийн болзол хангасан эсэхийг шалгана.

Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл - ПРОГРАМААС ГАРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛААР ҮЙЛЧИЛҮҮЛСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

Даатгуулагчийн регистрийн дугаарыг оруулж шалгах товчийг дарна уу!

11. **Даатгуулагч урамшууллын оношлогоо, шинжилгээнд хамрагдах эрхтэй бол:**

- Тухайн даатгуулагчийн урамшууллын эрхийн хугацаанд шалгах (даатгуулагч урамшууллын эрхийн баталгаажуулалтаа хийлгэснээс хойш 30 хоногийн дотор урамшууллын оношлогоо, шинжилгээндээ хамрагдах ёстой). Хэрэв даатгуулагчийн 30 хоногийн хугацаа хэтэрсэн тохиолдолд тухайн эмнэлэг үйлчлэхгүйг байхыг анхаарна уу.
- Даатгуулагч урамшууллын оношлогоо, шинжилгээндээ 30 хоногийн дотор хугацаандаа хамрагдсан тохиолдолд **“үйлчлүүлсэн тул тэмдэглэх”** товчийг дарж тухайн даатгуулагчид үйлчилгээ үзүүлснийг баталгаажуулна.

Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл - ПРОГРАМААС ГАРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛААР ҮЙЛЧИЛҮҮЛСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

☐0000000000 регистрийн дугаартай БАТЛУГА - д урамшууллын эрхийг 2014-08-08 -ний өдөр олгосон байна. **ҮЙЛЧИЛҮҮЛСЭН ТУЛ ТЭМДЭГЛЭХ**

1. Даатгуулагчийн урамшууллын эрхээ баталгаажуулсан огноог 30 хоногийн дотор байгаа эсэхийг шалгана уу!

Жишээ даатгуулагчийн хувьд 2014.09.07-ны дотор урамшууллын оношлогоо, шинжилгээнд хамрагдах ёстой.

2. Урамшууллын эрхээ баталгаажуулж, хугацаандаа урамшууллын оношлогоо, шинжилгээндээ хамрагдсан бол **“үйлчлүүлсэн тул тэмдэглэх”** товчийг дарж тухайн даатгуулагчдад үйлчилгээ үзүүлснээ баталгаажуулна уу!

Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл - ПРОГРАМААС ГАРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛААР ҮЙЛЧИЛҮҮЛСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ СИСТЕМ

Регистрийн дугаар оруулна уу :  ШАЛГАХ

☐0000000000 регистрийн дугаартай БАТЛУГА - нь урамшууллын эрхээр 2014-08-08 -ний өдөр Чингэлтэй эрүүл мэндийн нэгдэл эмнэлэгээр үйлчлүүлсэн байна. **ТЭМДЭГЛЭСНИЙГ ЦУЦЛАХ**

Хэрэв эмнэлэг даатгуулагчид үйлчилгээ үзүүлсэн эсэхээ бүрүү тэмдэглэсэн тохиолдолд **“тэмдэглэснийг цуцлах”** товчийг дарж буцаах боломжтой.